



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 02

Мандалговь

## Хөрөнгө худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14,559,130.00 /Арван дөрвөн сая таван зуун тавин есөн мянга нэг зуун гучин төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 38-04 ДУА улсын дугаартай УАЗ-31512 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн дарга /Ж.Рэнчинсамбуу/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэцэжид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СУХБААТАР

